



**ШИНЭ ИХ ТЭРБУМ
АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
1-р хороо, 12-р хороолол, North center, 204 тоот
Утас: 9919-9075, 8804-3708, И-мэйл: Ikhterbum@gmail.com

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

2024.01.10 № 24/01

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Тандэм инвест ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцээний тайлан, нэмэлт тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”)-ын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайланд аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЭЗОУСЗ”)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус байсан бөгөөд НБЭЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Бусад мэдээлэл

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”), хэрвээ байхгүй бол гүйцэтгэх удирдлага нь бусад мэдээллийг бэлтгэх үүрэгтэй. Бусад мэдээлэл нь ТУЗ-ийн тайлангийн хавсралт, бизнесийн хариуцлагын тайланг багтаасан мэдээллээс бүрдэнэ. Санхүүгийн тайланд хийсэн аудиттай холбогдуулан бидний үүрэг бол бусад мэдээлэлтэй танилцах бөгөөд бусад мэдээлэл нь бие даасан санхүүгийн тайланд эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх талаар авч үзэх явдал юм. Энэ талаар бидэнд мэдээлэх зүйл байхгүй болно

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)
“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Санхүүгийн тайланд ББСБ-ын удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах болон алдаа эсвэл залилангаас үүдэлтэй материаллаг алдаатай илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага нь компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ. Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлдэг гэсэн баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь залиланд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горим боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг авч үздэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсэх үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)
“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангах хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.


Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92, 94 дүгээр зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл, Компанийн дүрэмд заасан бусад мэдээллийг тайлагнах үүрэгтэй бөгөөд эдгээр зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор банк бус санхүүгийн байгууллагад мөрдүүлэхээр зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм, журмын даган мөрдөлтийн талаар горим гүйцэтгэсэн бөгөөд ББСБ нь Монгол улсын хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, журмыг ноцтойгоор зөрчсөн гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд ажиглагдаагүй.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу зөвхөн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.


Д. Дашдулам - Гүйцэтгэх захирал
“Шинэ их тэрбум аудит” ХХК
Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
1-р хороо, 12-р хороолол, Залуучуудын өргөн чөлөө
North center, 204 тоот

**“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

(Төгрөгөөр)

ХӨРӨНГӨ

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

	<i>Лав</i>	12/31/2023	12/31/2022
Бэлэн мөнгө	5	3,330,886	6,479,943
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	6	1,172,831,507	614,829,195
Зээл (цэвэр)	7	18,890,597,191	16,649,740,633
Бусад авлага	8	522,876,489	259,179,859
Бусад хөрөнгө	9	6,854,451	3,399,730
Эргэлтийн хөрөнгийн дүн		20,596,490,525	17,533,629,359

ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгө (цэвэр)	10	443,149,646	486,454,309
Биет бус хөрөнгө (цэвэр)	11	1,199,271	1,930,521
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		444,348,917	488,384,830

ХӨРӨНГИЙН ДҮН

21,040,839,442 **18,022,014,189**

ӨР ТӨЛБӨР

БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Итгэлцлийн үйлчилгээний өглөг	12	4,957,963,733	3,464,131,003
Бусад өр төлбөр	13	513,341,660	301,447,000
Богино хугацаат өр төлбөрийн дүн		5,471,305,393	3,765,578,003

Нийт өр төлбөрийн дүн

5,471,305,393 **3,765,578,003**

ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Хувьцаат капитал	14	3,465,098,908	3,465,098,908
Нэмж төлөгдсөн капитал	15	8,779,112,743	8,779,112,743
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	16	3,325,322,398	2,012,224,534
Эзэмшигчдийн өмчийн дүн		15,569,534,049	14,256,436,185

ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН

21,040,839,442 **18,022,014,189**

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно

**“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

		<u>(Төгрөгөөр)</u>	
	<u>Лав</u>	<u>12/31/2023</u>	<u>12/31/2022</u>
Хүүгийн орлого	17	5,451,099,992	3,051,928,920
Хүүгийн зардал		-	-
Цэвэр хүүгийн орлого		5,451,099,992	3,051,928,920
Хүүгийн бус орлого	18	72,282,210	181,935,424
Хүүгийн бус зардал	19	1,250,680,306	899,768,500
Цэвэр хүүгийн бус орлого (зардлын) дүн		(1,178,398,096)	(717,833,077)
Зээлийн эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг (алдагдал)		4,272,701,896	2,334,095,843
Зээлийн эрсдэлийн зардал	20	542,191,175	51,154,298
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)		3,730,510,721	2,282,941,545
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	21	550,000	267,300
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	22	54,341,881	62,268,328
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		3,676,718,840	2,220,940,518
Орлогын албан татварын зардал	23	373,284,334	227,324,564
Цэвэр ашиг (алдагдал)		3,303,434,505	1,993,615,954
Нэгж хувьцаанд ногдох ашиг		2.92	1.76

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.

“ТАНДЭМ ИНВЭСТ БЭСБ” ХК
 ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

	(Төгрөгөөр)				
	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
ҮЗҮҮЛЭЛТ					
2021 оны 12 дүгээр сарын 31-ний үлдэгдэл	2,601,501,521	(3,569,520)	2,294,210,377	979,761,261	5,871,903,939
Өмчид гарсан өөрчлөлт	867,167,107		6,484,901,366	-	7,352,068,973
Нягтлан бодох бүртгэлийн залруулга				35,421	35,421
Зарласан ногдол ашиг				(961,188,101)	(961,188,101)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				1,993,615,954	1,993,615,954
2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	3,468,668,428	(3,569,520)	8,779,112,743	2,012,224,534	14,256,436,185
Зарласан ногдол ашиг				(1,990,336,642)	(1,990,336,642)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				3,303,434,505	3,303,434,505
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	3,468,668,428	(3,569,520)	8,779,112,743	3,325,322,398	15,569,534,049

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2023	(Төгрөгөөр) 12/31/2022
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	17,899,653,767	14,840,857,279
Зээлийн хүүгийн орлого	5,181,720,281	2,871,548,131
Харилцах дансны хүүгийн орлого	15,396	-
Гадаад валютын ханшийн зөрүү	53,133	94,995,379
Итгэлцлийн орлого	651,272,200	2,890,467,000
Зээлийн эргэн төлөлтийн орлого	11,993,814,183	8,897,025,824
Үйлчилгээний шимтгэл, хураамжийн орлого	72,228,575	86,820,945
Бусад үйлчилгээний орлого	550,000	-
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	17,270,119,132	21,606,234,998
Үндсэн ба нэмэгдэл цалин	184,962,828	183,655,342
Ажилтануудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	575,440	1,264,079
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	54,805,681	43,843,761
Албан томилолт, сургалтын зардал	43,272,820	26,724,720
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	16,980,850	17,395,000
Шатахуун, холбоо, интернет, бэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	16,272,089	12,524,270
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	4,262,286	9,553,314
Татвар, даатгалын төлсөн мөнгө	666,784,124	283,347,414
Зээл болон түүнтэй холбогдох авлагыг барагдуулахад төлсөн мөнгө	1,192,527	595,000
Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан мөнгө	1,309,730,205	1,332,148,637
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	4,809,200	3,178,000
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	36,500,000	1,200,000
Ногдол ашгаар олгосон мөнгө	3,715,657	22,902,066
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	91,671,605	166,841,265
Харилцагчдад олгосон зээл	14,784,675,000	19,291,529,000
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	49,908,820	209,533,130
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	629,534,635	(6,765,377,719)
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	9,224,472	7,456,432,929
Бусад орлого	9,224,472	-
Нэмж төлөгдсөн капитал татварын орлогын буцаалт	-	7,456,432,929
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	83,905,852	519,315,491
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	29,563,971	470,279,239
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	54,341,881	49,036,252
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(74,681,380)	6,937,117,438
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	554,853,255	171,739,719
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	621,309,138	449,569,419
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,176,162,393	621,309,138

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. ББСБ-ын үйл ажиллагааны мэдээлэл

“Тандэм инвест ББСБ” ХК нь Монгол улсын “Компанийн тухай” хуулийн дагуу хувьцаат компани хэлбэрээр зохион байгуулагдсан Монгол улсын хуулийн этгээд бөгөөд 2005 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Улсын бүртгэлд 9010001130 тоот гэрчилгээ, 2013916 тоот регистртэй бүртгэгдсэн.

Монгол улсын Санхүүгийн Зохицуулах хороо (цаашид СЗХ)-ны 2011 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 6 дугаар тогтоолоор Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх 101/214 тоот гэрчилгээтэй, 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 278 дугаар тогтоолоор итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж авсан.

ББСБ нь үйл ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд дараах үйлчилгээний тусгай зөвшөөрлүүдийг шат дараатайгаар нэмж авахаар ажиллаж байна.

- Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх
- Факторинг
- Төлбөрийн баталгаа гаргах
- Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ

ББСБ-ын хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Чулуун Чинзориг	ХЙ73111619	44.83%	676,162,810	2.3	1,555,174,463
2	Шинтани Михоко	JPN7503049F	20.00%	301,649,958	2.3	693,794,903
3	Шинтани Такаёши	JPN4106151M	34.95%	527,034,444	2.3	1,212,179,221
4	Олон нийт		0.22%	3,269,496	2.3	7,519,841
	Нийт		100%	1,508,116,708		3,468,668,428

Үйл ажиллагааны чиглэл:

ББСБ-ын шинэчилсэн дүрэмд зааснаар зээл, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн. Зээлийн бүтээгдэхүүн нь хэрэглээний, бизнесийн болон орон сууцны гэсэн үндсэн 3 төрөлтэй.

ББСБ нь Санхүүгийн зохицуулах хорооны 669 тоот тогтоолын дагуу Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож компанийн үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орсон тул ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “Компанийн шинэчилсэн дүрэм”-ийг баталж, мөрдөн ажиллаж байна.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Бизнесийн үндсэн хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Эрхи төв, 402 тоот
Утас: 976-70151510

И-мэйл хаяг: tandeminvest.nbfi@gmail.com

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд

2.1 Тайланг бэлтгэх үндэслэл

Компанийн санхүүгийн тайлангууд нь НББОУСЗ-өөс гаргасан СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг Компанийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр толилуулсан. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд төгрөгөөр тайлагнасан.

2.2 Тасралтгүй үйл ажиллагаа

Компани одоо болон аял ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл

Компани нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Төсөөлөл, тооцооллуудын үнэлгээг байнга хийх ба эдгээр нь удирдлагын туршлага болон тухайн нөхцөл байдлын хувьд ирээдүйд тохиолдож болохуйц хүлээлт зэрэг хүчин зүйлүүд дээр суурилдаг.

2.4 Бодит үнэ цэнийн хэмжилт

Санхүүгийн тайланд хэд хэдэн хөрөнгө, өр төлбөрийг бодит үнэ цэнээр нь хэмжиж, тодруулахыг шаарддаг. Компани санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн хэмжилтийг боломжит хэмжээнд хэрэглэдэг.

Зах зээлийн оролцогчид нь хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоох үед өөртөө эдийн засгийн хувьд хамгийн ашигтай байхаар оролцоно гэсэн төсөөллийг ашиглан хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжинэ.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон толилуулгад орсон өөрчлөлтүүд

Компани 2023 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа доорх стандарт болон стандартын нэмэлт өөрчлөлтүүдээс бусад тохиолдолд өмнөх санхүүгийн жилд мөрдөж байсан бүртгэлийн бодлогуудаа энэ санхүүгийн жилд тууштай мөрдөж байгаа болно.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Шинэ болон өөрчлөгдсөн стандарт болон стандартын тайлбарууд

Хэрэгжиж эхэлсэн хугацаа	Шинэчлэгдсэн СТОУС болон өөрчлөлтүүд
2023.01.01	<i>СТОУС 17 – Даатгалын гэрээ</i> Энэхүү стандартын гол зорилго нь даатгалын гэрээг үнэн зөв илэрхийлэх, холбогдох мэдээллийг аж ахуйн нэгж бэлтгэдэг эсэхийг ханган магадлахад оршино. Энэ мэдээлэл нь аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд тухайн даатгалын гэрээний үзүүлэх үр нөлөөг санхүүгийн тайлангийн хэрэглэгч нар үнэлэх суурь үндэслэлээр хангадаг.
2023.01.01	<i>СТОУС 17 – Даатгалын гэрээ</i> СТОУС-17-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд
2023.01.01	<i>НББОУС-8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа</i> Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолтын нэмэлт өөрчлөлт
2023.01.01	<i>НББОУС-12 Орлогын албан татвар</i> Хойшлогдсон татварын хөрөнгийн өөрчлөлт
2023.01.01	<i>НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга</i> Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгын өөрчлөлт
2023.01.01	<i>НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга</i> Эргэлтийн ба эргэлтийн бус хөрөнгийн ангиллын өөрчлөлт
2023.01.01	<i>НББОУС 12 Орлогын албан татвар - Нэг удаагийн гүйлгээний үр дүнд бий болсон хороого, ор толбортэй колбоотой хойшлогдсон татварын нэмэлт өөрчлөлт</i>
2023.05.23	<i>НББОУС 12 Орлогын албан татвар – Олон улсын татварын шинэчлэл – Хоёрдугаар тулгуур загварын дүрмийн нэмэлт өөрчлөлт</i>

Дээрх шинэ стандарт болон стандартуудын нэмэлт өөрчлөлт нь Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлээгүй.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд

Хэрэгжих хугацаа	Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд
2024.01.01	<i>СТОУС-16 Түрээс</i> <i>Борлуулах ба буцаан түрээслэхтэй холбоотой хувьсах төлбөрийн өөрчлөлт</i>
2024.01.01	<i>НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга</i> <i>Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал, эргэлтийн бус өр төлбөрийн гэрээгээр хүлээх үүрэг хариуцлагын талаарх өөрчлөлт</i>
2024.01.01	<i>НББОУС 7 Мөнгөн гүйлгээний тайлан, СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга Нийлүүлэгчийн санхүүжилтийн зохицуулалтын нэмэлт өөрчлөлтүүд</i>
2024.01.01	СТОУС-ТБ1 Тогтвортой байдалд хамаарах санхүүгийн мэдээллийг тодруулах ерөнхий шаардлага
2024.01.01	СТОУС-ТБ2 Уур амьсгалтай холбоотой тодруулга
2025.01.01	НББОУС 21 Гадаад валютын ханшийн үр нөлөө Арилжааны алдагдлын талаарх нэмэлт өөрчлөлт

Дээрх шинэ болон шинэчлэгдсэн зарим СТОУС-ын хэрэгжилт нь компанийн санхүүгийн үр дүнд ирээдүйд нөлөө үзүүлж болзошгүй гэж урьдчилан таамаглаж байна.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо

4.1 Эргэлтийн болон эргэлтийн бус ангилал

Компани хөрөнгө болон өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайланд эргэлтийн болон эргэлтийн бус ангиллын дагуу толилуулна. Дараах тохиолдолд хөрөнгө эргэлтийн хөрөнгө болно:

- Хэвийн үйл ажиллагааны явцад хэрэгжих болон борлуулах хандлагатай эсвэл хэрэглэхээр хүлээгдэж байгаа
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор хэрэгжихээр хүлээгдэж байгаа эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сарын дотор солилцох эсвэл өр төлбөр барагдуулахыг хязгаарлаагүй бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Бусад бүх хөрөнгө нь эргэлтийн бус хөрөнгө болно.

Өр төлбөр нь дараах тохиолдлуудад богино хугацаат өр төлбөр болно:

- Хэвийн үйл ажиллагааны явцад төлөгдөхөөр хүлээгдэж буй
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор төлөх хугацаатай, эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сар өр төлбөр барагдуулалтыг хойшлуулах нөхцөлгүй

Компани бусад бүх өр төлбөрүүдийг эргэлтийн бус гэж ангилдаг.

4.2 Санхүүгийн хөрөнгө, өр төлбөр

Хөрөнгө болон өр төлбөр нь мөнгө, түүнтэй адилтгах зүйлс, зээл, бусад авлага, өглөг, урьдчилж төлсөн тооцоо, үндсэн ба биет бус хөрөнгө зэргээс бүрддэг.

Санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь тухайн өдрийн идэвхтэй зах зээлийн жишиг үнэ юм. Хэрвээ санхүүгийн хөрөнгийн зах зээл идэвхтэй биш бол үнэлгээний аргыг ашиглан бодит үнэ цэнийг тогтоох ба ямар арга хэрэглэх талаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгаж мөрдөнө.

Санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжих боломжгүй тохиолдолд өртгөөр нь бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгийн үнэлгээ, хэмжилт нь түүний ангиллаас шалтгаалах тул үнэт цаасны ангиллыг тодорхойлсны дараа үнэлнэ. Дараах ангиллын дагуу бүртгэнэ.

Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх санхүүгийн хөрөнгө

Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх санхүүгийн хөрөнгийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр хэмжиж, бүртгэнэ. Энэ нь тухайн санхүүгийн хөрөнгийг худалдан авахад төлсөн мөнгөн дүнтэй тэнцүү байна. Харин санхүүгийн хөрөнгийг худалдан авахтай шууд холбоотой брокерийн шимтгэл, буцаагдахгүй татвар, үнэт цаасны

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

арилжааны шимтгэл зэргийг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа энэ ангиллын санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр дахин үнэлэх ба бодит үнэ цэнд гарсан өсөлт, бууралтыг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ. Энэ ангиллын өрийн хэрэгслийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолж тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрнө.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа энэ ангиллын санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр дахин үнэлэх ба бодит үнэ цэнд гарсан өсөлт, бууралтыг эздийн өмчийн дансанд бүртгэж, тайлант хугацааны бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө. Энэ ангиллын өрийн хэрэгслийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолж, тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрнө. Хэрэв энэ ангиллын санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бурсан бодитой нотолгоо байгаа бол үнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Хорогдуулсан өртгөөр илэрхийлэх санхүүгийн хөрөнгө

Хорогдуулсан өртгөөр илэрхийлэх санхүүгийн хөрөнгийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнэ дээр холбогдох шууд зардлыг нэмсэн дүнгээр бүртгэнэ. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа энэ ангиллын санхүүгийн хөрөнгийг санхүүгийн тайланд хорогдуулсан өртгөөр үнэлж, толилууна. Хэрэв энэ ангиллын санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан бодитой нотолгоо байгаа бол үнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Хорогдуулсан өртгөөр илэрхийлэх санхүүгийн хөрөнгийн хувьд гэрээнд заасан мөнгөн төлбөрийг авч, өгөөж хүртэхийн тулд хөрөнгийг эзэмших зорилго бүхий бизнесийн загварт нийцэх ба гэрээний дагуу санхүүгийн хэрэгслийн үлдсэн дүн ба хүү заасан хугацаанд төлөгддөг байх гэсэн хоёр нөхцөл хангагдсан байна.

4.3 Монгол хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Монгол хөрөнгө нь төгрөгөөр илэрхийлэгдэх гар дээрх бэлэн мөнгө, банкин дахь төгрөг, ам доллар, иенийн дансуудаас бүрддэг.

4.4 Зээл, зээлийн эрсдэлийн сан

Зээлийг олгосон дүнгээр нь бүртгэдэг ба урьдчилан тооцсон цэвэр боломжит хэмжээгээр үнэлэгддэг. Зээлийн цэвэр дүн нь өрийн үлдэгдлээс түүнд байгуулсан зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна.

Холбогдох журмын дагуу зээлээ ангилж, тухайн ангиллын дансаар бүртгэдэг. Зээлийн ангилалд тохирсон зээлийн эрсдэлийн санг тайлант хугацааны зардлаар байгуулдаг. Хэрэв буцаах дүн эрсдэлийн зардлын дүнгээс илүү бол зөрүү дүнгээр тайлант хугацааны орлого болгож бүртгэдэг.

Холбогдох журмын дагуу зээлээ ангилж, тухайн ангиллын дансаар бүртгэдэг. Зээлийн ангилалд тохирсон зээлийн эрсдэлийн санг тайлант хугацааны зардлаар байгуулдаг. Хэрэв буцаах дүн эрсдэлийн зардлын дүнгээс илүү бол зөрүү дүнгээр тайлант хугацааны орлого болгож бүртгэдэг.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

ББСБ-ын активын эрсдэлийн сан байгуулах хувь нь Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 998 тоот тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу дараах хувь хэмжээгээр байгуулж, зээлийн эрсдэлийн санг тооцсон байна.

<i>Активын ангилал</i>	<i>Хувь хэмжээ</i>	<i>Зээлийн эрсдэлийн сан</i>
Хугацаа хэтэрсэн зээл	5%	70,434,096
Хэвийн бус зээл	25%	155,242,831
Эргэлзээтэй зээл	50%	206,507,807
Муу зээл	100%	249,614,900
Нийт дүн		681,799,633

4.5 Санхүүгийн хэрэгслүүд

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр нь мөнгө, түүнтэй адилтгах зүйлс, дансны ба бусад авлага, дансны ба бусад өглөг, зээл зэргээс бүрддэг. ББСБ санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ.

4.6 Санхүүгийн хөрөнгө, өр төлбөр

	2023/12/31	2022/12/31
Мөнгөн хөрөнгө	1,176,162,393	621,309,138
Зээл (цэвэр)	18,890,597,191	16,649,740,633
Зээлийн хүүгийн авлага	522,876,489	259,179,859
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	4,957,963,733	3,464,131,003
Хуримтлуулж тооцсон итгэлцлийн хүүгийн өглөг	242,423,544	111,520,839
Нийт санхүүгийн хөрөнгө	20,589,636,073	17,530,229,629
Нийт санхүүгийн өр төлбөр	5,200,387,277	3,575,651,842

4.7 Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Удирдлага нь ББСБ-ын эрсдэлийн удирдлагын бодлогод гол үүрэг хариуцлага хүлээхийн зэрэгцээ түүнийг тодорхойлж бэлтгэх үүрэгтэй байдаг.

ББСБ нь үйл ажиллагааны явцад дараах санхүүгийн эрсдэлүүдэд өртөх магадлалтай. Үүнд:

- Зээлийн эрсдэл
- Зах зээлийн эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

а) Зээлийн эрсдэл:

Зээлийн эрсдэл нь ББСБ-д санхүүгийн эрсдэл үүссэний улмаас гэрээний үүргээ гүйцэтгэж чадахгүй болох эрсдэлийг харуулдаг. ББСБ тайлант хугацаанд материаллаг хэмжээний хэвийн бус, эргэлзээтэй, муу зээлүүдтэй тул зээлийн эрсдэлд өртөх магадлалтай байна.

б) Зах зээлийн эрсдэл:

Зах зээлийн эрсдэл нь тухайн байгууллагад учирч болох гадаад хүчин зүйл буюу банкны салбар, хөрөнгийн зах зээлийн үнийн хэлбэлзэл, гадаад валютын ханшийн өөрчлөлт, хууль зүй, татварын бодлого гэх мэт зах зээлийн орчноос хамаарч байгаа эрсдэл юм.

Хүүгийн түвшний эрсдэл гэдэг нь зах зээл дээрх зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм. ББСБ нь зээлийн хүүг холбогдох журмын дагуу тогтоолог тул хүүгийн түвшний эрсдэлд өртөх магадлалтай.

в) Төлбөрийн чадварын эрсдэл:

Төлбөрийн чадварын эрсдэл нь ажлын капитал, зээлийн хэрэглүүр дэх санхүүгийн төлбөр, үндсэн өрийг төлж барагдуулахтай холбоотой үүсдэг. Энэ нь ББСБ санхүүгийн өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулахад хүндрэлтэй тулгарах эрсдэл юм.

ББСБ-ын баримтлах бодлого бол үүргийн гүйцэтгэлийн хугацааны эцэст түүнийг барагдуулах хангалттай бэлэн мөнгөтэй байх явдал юм. ББСБ 2023 оны 12 сарын 31-нээр бусад санхүүгийн байгууллага, хувь хүмүүсээс авсан зээлгүй тул төлбөрийн чадварын эрсдэлд өртөх магадлал бага байна.

4.8 Зээлийн барьцаа, батлан даалтын хөрөнгө

Зээлийн барьцаанд авсан эд хөрөнгө болон эд хөрөнгийг эзэмших эрхийг тэнцлийн гадуурх зээлийн барьцаа хөрөнгийн дансанд орлогодож, зээлдэгч зээлийг бүрэн төлсөн нөхцөлд тухайн данснаас зарлагдадаг.

4.9 Бусад авлага

Авлага нь хүлээн авахаар урьдчилан тооцсон цэвэр боломжит хэмжээгээр үнэлэгдэнэ. Өөрөөр хэлбэл, түүний нэрлэсэн үнээс найдваргүй авлагад байгуулсан эрсдэлийн санг хасч тооцсон төлөгдөх боломжтой цэвэр дүнгээр илэрхийлдэг. Авлага нь хуримтлуулж тооцсон хүүгийн авлагаас бүрдэж байна.

4.10 Бусад хөрөнгө

Бусад хөрөнгөд урьдчилгаа, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө, материал үнэ бүхий зүйлс, бусад хөрөнгөөс бүрдэнэ.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Банк бус санхүүгийн байгууллагын урьдчилж төлсөн тооцоо нь хамтран ажиллагч байгууллага болон харилцагчдад төлсөн төлбөрөөс бүрдэж байна. Бусад авлага нь хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлагаас бүрдэж байна.

4.11 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэдэг. Үндсэн хөрөнгийн анхны өртөгт худалдан авсан үнэ, түүнийг бэлтгэхтэй холбогдон гарсан аливаа зардлыг оруулдаг. Хандиваар авсан хөрөнгийг зах зээлийн үнээр бүртгэнэ.

Үндсэн хөрөнгө нь анхны өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хасч тооцсон үлдэгдэл өртгөөр илэрхийлэгддэг. Тэнцлийн үнэлгээ зах зээлийн үнэлгээнээс зөрөх тохиолдолд байгууллага, ТУЗ-ийн шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийж, энэ талаар санхүүгийн тайланд тайлбар хийнэ.

Үндсэн хөрөнгүүдэд дариах хувь хэмжээгээр элэгдэл байгуулсан болно.

Үндсэн хөрөнгийн ангилал	Хувь хэмжээ	Ашиглагдах хугацаа
Барилга байгууламж	2%	25
Тавилга, эд хогшил	10%	10
Компьютер, дагалдах хэрэгсэл	50%	2
Тээврийн хэрэгсэл	10%	10

4.12 Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийг анхны өртгөөр үнэлэх бөгөөд тодорхой хугацаанд өнөөгийн цэвэр үнэ цэнээр дахин үнэлж болно. Биет бус хөрөнгийг анхны өртгөөс хорогдуулалтыг хассан дүнгээр бүртгэдэг. Биет бус хөрөнгийн хорогдол тооцох өртөг нь хөрөнгийн анхны өртгөөс үлдэх өртгийг хассан дүн байна.

4.13 Түрээс

Тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлохдоо гэрээний агуулга дээр үндэслэх ба гэрээг гүйцэтгэхэд тусгай хөрөнгийг ашиглах шаардлагатай эсэх ба гэрээ нь хөрөнгийг ашиглах эрхийг шилжүүлж байгаа эсэх зэргийг үнэлж үзэх шаардлагатай.

Компани богино хугацаат түрээс болон бага үнэ цэнэ бүхий хөрөнгийн түрээсээс бусад бүх түрээсийн хүлээн зөвшөөрөлт болон хэмжилтийн нэг аргыг хэрэглэнэ. Компани түрээсийн төлбөрийг төлөөлж “түрээсийн өр төлбөр”-ийг хүлээн зөвшөөрч, тодорхойлсон хөрөнгийг түрээслэн ашиглах эрхийг төлөөлж “ашиглах эрхтэй хөрөнгө”-ийг хүлээн зөвшөөрнө.

Компани ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн эхлэх өдөр эхлэн хүлээн зөвшөөрнө. Ашиглах эрхтэй хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, аливаа үнэ цэнийн бууралтын

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

алдагдлыг хасч өртгөөр нь хэмжих бөгөөд түрээсийн өр төлбөрийг дахин үнэлэхэд тохируулна. Ашиглах эрхтэй хөрөнгийн өртөг нь хүлээн зөвөөрөгдсөн түрээсийн өр төлбөр, анхны шууд өртөг, түрээсийн урамшууллыг хүлээн авахаас өмнө буюу өмнөх өдрөөс эхлэн хийсэн түрээсийн төлбөрүүд багтана.

Компани түрээсийн хугацааны туршид төлөх төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнээр хэмжсэн түрээсийн өр төлбөрийг түрээс эхлэх өдөр хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөр гэдэгт аливаа урамшуулал хөнгөлөлтийг хассан түрээсийн тогтмол төлбөрөөс гадна хувь хэмжээнээс хамаарах хувьсах шинжтэй төлбөр, үлдэгдэл үнийн баталгааны дагуу төлөхөөр хүлээгдэж буй төлбөрүүдийг хамааруулан авч үзнэ.

4.14 Өр төлбөр

Санхүүгийн бусад эх үүсвэрийн өглөгийг эргүүлж төлөх дүнгээр санхүүгийн тайланд бүртгэдэг. Холбогдох хөрөнгө, зардал буюу алдагдлыг хүлээн зөвшөөрсөн үед өр төлбөрийг бүртгэдэг.

Банк бус санхүүгийн байгууллага нь тайлант хугацаанд дансны өглөгийн үлдэгдэлгүй болно.

4.15 Итгэлцлийн үйлчилгээний өглөг

Итгэлцлийн үйлчилгээ гэж итгэл хүлээлгэгчийн активыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээлгэгчээс нэр бүхий активыг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг хэлнэ.

Итгэлцлийн үйлчилгээний өглөгийг гэрээнд заасны дагуу нэрлэсэн үнээр нь бүртгэдэг.

4.16 Бусад төлбөр

Бусад өр төлбөрийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг, татварын өглөг, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, цалингийн өглөг, бусад өглөгийн дансыг тооцоо үүссэн тухай бүр зохих дансад бичилт хийж бүртгэдэг.

Банк бус санхүүгийн байгууллага нь тайлант хугацаанд хуримтлуулж тооцсон бусад хүүний өглөг, татварын өрийн үлдэгдэлтэй байна.

4.17 Эзэмшигчдийн өмч

Эзэмшигчдийн өмч буюу капитал нь оруулсан капитал болон олсон капиталын нийлбэр юм. Эзэмшигчдийн өмч нь нийт хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хассан дүнтэй тэнцүү байна. Эзэмшигчийн өмчийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Тайлант жилийн эцэст хаалтын гүйлгээ хийж, тухайн жилийн цэвэр ашиг, алдагдлыг тодорхойлдог. Тайлант үеийн болон өмнөх үеийн хуримтлагдсан ашгийг тусад нь нэрийн дансаар бүртгэдэг.

4.18 Орлого

Үндсэн үйл ажиллагааны орлого нь хугацаандаа байгаа ба хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн, харилцах, хадгаламжийн дансны хүүгийн, мөнгөн гуйвуулгын ба үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого зэргээс бүрддэг.

4.18.1 Хүүгийн орлого

Хүүгийн орлого нь тодорхой гэрээний үндсэн дээр зээлдэгчдэд олгосон зээл, бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөнд тэдгээрийг ашиглуулсны төлөө авч буй хариу төлбөрөөс бүрддэг. Хүүгийн орлогыг нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бүртгэдэг.

4.18.2 Хүүгийн бус орлого

Хүүгийн бус орлогод зээлдэгчдээс авсан үйлчилгээний шимтгэл, хураамж, арилжаа болон ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого орно. Үйлчилгээ үзүүлснээс орох орлогыг ихэнхдээ уг үйл явдал болсон үед нь орлогоор хүлээн зөвшөөрдөг.

4.19 Зардал

Зардал нь үйл ажиллагааны зардал болон бусад зардал, гарзыг хамааруулна. Эдийн засгийн үр ашгийн бууралт нь хөрөнгийн үнэлгээг бууруулах буюу өр төлбөрийг нэмэгдүүлж байгаа бөгөөд хэмжиж болохуйц байвал зардлыг хүлээн зөвшөөрдөг.

4.19.1 Хүүгийн зардал

Хүүгийн зардал нь ББСБ-ын үйл ажиллагааны эх үүсвэрт ашиглахын тулд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлбөр буюу өртөг юм. Хүүгийн зардлыг татан төвлөрүүлсэн хөрөнгийн төрлөөр ангилж бүртгэнэ.

4.19.2 Хүүгийн бус зардал

Хүүгийн бус зардалд хүүгийн зардлаас бусад үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарч байгаа үйлчилгээ, маркетинг, удирдлагын зардал ордог. Үйл ажиллагааны бусад зардлыг зардлын төрлөөр ангилж бүртгэдэг.

4.19.3 Үндсэн бус үйл ажиллагааны зардал

Үндсэн бус үйл ажиллагааны зардлыг зардлын төрлөөр нь ангилж бүртгэдэг. Тухайлбал баяр ёслол, хандив, зочин төлөөлөгчийн зардлаас бүрддэг.

4.20 Гадаад валютын гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдрөөр зарласан ханшийг ашиглаж, “анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр” хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн үлдэгдэлд тайлант хугацааны эцсийн өдрөөр Монголбанкнаас зарласан албан ханшаар ханшийн тэгшитгэл хийдэг.

Түүхэн өртгөөр илэрхийлэгдсэн гадаад валютаарх мөнгөн бус зүйлсийн үлдэгдэлд ханшийн тэгшитгэл хийдэггүй. Ханшийн өөрчлөлтийн улмаас гарсан зөрүүг орлогын дэлгэрэнгүй тайланд ханшийн тэгшитгэлийн олз, гарзаар хүлээн зөвшөөрдөг.

4.21 Тэнцлийн гадуурх данс

Тэнцлийн гадуурх данс нь хүлээж болзошгүй үүрэг үнэ бүхий зүйлс, тэнцлээс хасагдсан хөрөнгийн тооцоо зэрэг зарим үйл ажиллагааг нарийвчлан тусгах бүртгэл юм. Тэнцлийн гадуур бүртгэлтэй зүйлсийг нэрлэсэн үнэ болон тоо ширхэгээр нь бүртгэдэг. Тэнцлийн гадуурх дансанд зөвхөн орлогодох эсвэл зарлагадах бичилт хийдэг.

4.22 Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага

Аж ахуйн нэгж нь болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй. Эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг зарцуулах магадлал нь бага байхаас бусад тохиолдолд энэхүү стандартаар шаардсанчлан, болзошгүй өр төлбөрийг тодруулна. ББСБ нь 2023.12.31-нээр болзошгүй өр төлбөрийн үлдэгдэлгүй.

4.23 Холбоотой талууд

НББОУС 24 Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг
- Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй
- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Дараах нөхцлүүдийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгж компанитай холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон компани нь нэг группын бүрэлдэхүүнд багтаж байвал өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанид хамаардаг охин компаниудад бүгд бусадтайгаа холбоотой;
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хяналттай компани бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан группын нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтын хяналттай компани бол;
- Хоёр аж ахуйн нэгж хоёулаа гуравдагч талын хамтын хяналттай компани бол;
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч талын хамтын хяналттай компани ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч талын хараат компани бол;
- Дээр тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид хяналт тавьдаг эсвэл хамтран хянадаг бол;
- Дээр тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид мэдэгдэхүйц нөлөөтэй эсвэл уг аж ахуйн нэгж эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Компанийн холбоотой этгээдэд Монгол улсын Компанийн тухай хуулийн 99.1 дэх заалтад тодорхойлсон хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагууд болон тэдний гэр бүл, хамаатан садангууд, компанийн ажиллагсад зэрэг иргэн, хуулийн этгээд хамаарна.

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр ББСБ-ын холбоотой талуудад дараах хувь хүмүүс хамаарч байна.

Харилцан холбоо	Холбоотой талууд
Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч	Ч.Чинзориг
Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч	Шинтани Михоко
Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч	Шинтани Такаёши
Гүйцэтгэх удирдлага	Ж.Ганхүлэг

Гол удирдах албан тушаалтан, ажилчдад олгосон зээлийн мэдээ:

/төгрөгөөр/

Холбоотой тал	Зээлийн дүн	Хүү	Нийт
ТУЗ-ийн холбоотой тал*	70,000,000	1,495,891	71,495,891
Нийт зээл	70,000,000	1,495,891	71,495,891

*Тайлант хугацаанд зээл төлөгдөж дууссан.

Голлох удирдлагын тайлант оны цалин хөлс, урамшуулал, холбогдох бусад тэтгэмжийн зардал дараах байдалтай байна.

Зардал	Зээлийн дүн
Цалин хөлс урамшуулал	153,760,279
Нийгмийн даатгалын зардал	19,024,726
Нийт	172,785,005

Хаалттай хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийн мэдээ:

/төгрөгөөр/

Хувьцаа эзэмшигч	Дүн
Шинтани Такаёши*	7,352,068,973

*ТУЗ-ийн 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 4 дүгээр дугаарын тогтоолоор ББСБ-ын эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор 377,029,177 ширхэг энгийн хувьцааг нэг бүрийг 19.5 төгрөгөөр хаалттай хүрээнд гаргасан.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Итгэлцлийн өглөгийн мэдээ:

/төгрөгөөр/

Холбоотой тал	Дүн
Хувьцаа эзэмшигч	3,837,328,732
ТУЗ-ийн гишүүд	100,000,000
Холбоотой компани	257,796,042
Нийт	4,195,124,774

4.24 Капиталын удирдлага

Компанийн капиталын удирдлагын зорилгоор, капиталд зарцуулсан капитал, хөрвөх похцолтэй хувьцаа, хувьцааны урамшуулал болон эздийн өмчид хуваарилагдах бусад бүх капиталын нөөцийг оруулна. Компанийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь өөрийн бизнесийг дэмжих ба хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

4.25 Балансын дараах үйл явдал

ББСБ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн тайлагналын өдрөөс хойш аудитын дүгнэлт гаргах хүртэлх хугацаанд уг санхүүгийн тайланд нөлөөлөхүйц материаллаг дүн бүхий ажил гүйлгээ гараагүй. 2024 онд бүтээгдэхүүн үйлчилгээг цахим болгох зорилгоор “Рэйн Жи Ти Си” ХХК-ийг нэгтгэх төслийн ажил бэлтгэл үе шатанд явагдаж байна.

4.26 Татвар

Орлогын албан татвар

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Тайлант жилийн татвар гэдэг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод тайлагналын өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын хүлээгдэж буй өр эсвэл авлага болон өмнөх жилүүдийн татварын өртэй холбоотой залруулгаас бүрдэнэ.

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлагналын болон татварын зорилгоор тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийн хооронд үүссэн түр зөрүүтэй холбоотойгоор хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно.

Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах орлогод 10%-иар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлогод 25%-иар татвар ногдуулан төлөхөөр шинэчилсэн. Мөн жилийн 300 сая төгрөг хүртэл албан татвар ногдох орлого олсон ашигт

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах; согтууруулах ундаа, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох; газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос хайх, олборлох, борлуулахаас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн тухайн албан татвар ногдуулах орлогод 1 хувиар орлогын албан татвар төлнө.

4.27 Нэмэгдсэн өртгийн албан татвар

Компани нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн дагуу чөлөөлөгдсөн.

4.28 Хувь хүний орлогын албан татвар

Хувь хүний орлогын албан татварыг ажиллагсдын цалин болон түүнтэй адилтгах орлого мөн гэрээт ажил гүйцэтгэгчийн хөлснөөс 10 хувиар тооцон ногдуулдаг. Ажил олгогч эсвэл үйлчилгээ хүлээн авагч нь ажиллагчдын цалин болон гэрээт ажлын хөлснөөс хувь хүний орлогын албан татварыг суутгаж, ажиллагсад болон гэрээт ажилчдын нэр дээр татварын байгууллагад шилжүүлдэг.

4.29 Нийгмийн даатгалын шимтгэл

Ажил олгогч болон байгууллага нь ажиллагсдын цалин болон түүнтэй адилтгах орлого мөн гэрээт ажил гүйцэтгэгчийн хөлснөөс даатгуулагч 11.5 хувиар, ажил олгогч 12.5 хувиар нийгмийн даатгалын шимтгэл суутгадаг ба сар бүрийн цалин болон үйлчилгээний хөлснөөс суутгах нийгмийн даатгалын шимтгэлийн дээд хэмжээ нь 483,000 төгрөг болсон.

Ажиллагсдын төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч болон үйлчилгээг хүлээн авагч суутгаж нийгмийн даатгалын байгууллагад шилжүүлдэг.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. БЭЛЭН МӨНГӨ

	12/31/2023	12/31/2022
Касс дахь бэлэн мөнгө (MNT)	3,330,886	6,479,943
	3,330,886	6,479,943

6. БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ

	12/31/2023	12/31/2022
Харилцах Хаан банк (MNT) 5030789445	1,155,258,475	388,566,441
Харилцах Төрийн банк (MNT) 102300346442	16,310,652	224,982,716
Харилцах Төрийн банк (MNT) 102300340838	300	300
Харилцах Төрийн банк (USD) 349900304303	466,514	492,888
Хяригчлал Хаан банк (JPY) 5628211209	2,538	28,198
Харилцах Голомт банк (MNT) 1505187598	600,745	558,200
Харилцах Голомт банк (JPY) 1505187600	192,283	200,452
Харилцах дансны дүн	1,172,831,507	614,829,195
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	1,176,162,393	621,309,138

*Харилцахын гадаад валютаар илэрхийлэгдсэн үлдэгдэл нь 8,043.78 иен, 136.78 ам доллартай тэнцүү байна.

**Мөнгөн хөрөнгийн 0.28%-ийг бэлэн мөнгө, 99.72%-ийг банкинд байгаа мөнгө эзэлж байна.

7. ЗЭЭЛ (ЦЭВЭР)

	12/31/2023	12/31/2022
Хэвийн зээл (Хувийн сектор)	1,028,902,623	1,444,565,330
Хэвийн зээл (Иргэд)	15,784,710,449	14,749,156,379
Хэвийн зээл (Иргэд)	66,500,000	66,500,000
Хугацаа хэтэрсэн зээл- Төгрөг /Иргэд/	1,408,681,916	323,978,590
Хэвийн бус зээл (Иргэд)	620,971,323	87,686,215
Эргэлзээтэй зээл (Хувийн сектор)	100,000,000	-
Эргэлзээтэй зээл (Иргэд)	313,015,614	31,949,205
Муу зээл (Иргэд)*	249,614,900	85,513,373
Зээлийн эрсдлийн сан**	(681,799,633)	(139,608,458)
	18,890,597,191	16,649,740,633

Тайлант хугацаанд нийт 680 иргэнд 14,314,675.0 мянган төгрөг, 3 хуулийн этгээдэд 470,000.0 мянган төгрөгийн зээл шинээр олгож, тайлант хугацааны эцэст идэвхитэй 1293 зээлдэгчийн 19,572,396.8 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй ба 445 зээл хаагдсан байна. Цэвэр зээл нь нийт активын 90%-ийг эзэлж байна. Зээл олголт өмнөх оноос 23 гаруй хувиар буурсан.

*Нийт идэвхитэй зээлийн үлдэгдлээс 13 зээлдэгчийн 249,614.9 мянган төгрөгийн буюу нийт зээлийн 1% нь муу зээл эзэлж байна.

Тайлант хугацааны зээлийн дундаж хүү сарын 2.64% байна.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Зээлдэгчид олгосон зээлийн ангилал болон насжилтыг дор харуулав.

Зээлийн ангилал /хувиар/	Зээлийн насжилт /мянган төгрөгөөр/		
	Эзлэх хувь	Хугацаа	Зээл
Хэрэглээнд зориулсан зээл	0.28%	1-12 сар	54,551
Бизнесийн үйл ажиллагаанд зориулсан зээл	5.76%	36 сар	1,126,614
Автомашин худалдан авахад зориулсан зээл	84.93%	36 сар	16,622,352
Үл хөдлөх эд хөрөнгөд худалдан авахад зориулсан зээл	2.37%	15 жил	463,190
Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээл	6.67%	2 жил	1,305,690
		Нийт	19,572,397

Зээлийг шилжилт хөдөлгөөнөөр харуулбал:

Шилжилт	Хэвийн	Хугацаа хэтэрсэн зээл	Хэвийн бус	Эргэлзээтэй	/мянган төгрөгөөр/	
					Муу зээл	Нийт
Эхний үлдэгдэл	16,260,222	323,979	87,686	31,949	85,513	16,789,349
Тайлант жилд олгосон	14,784,675					14,784,675
Зээлийн эргэн төлөлт	(10,891,263)	(703,113)	(236,538)	(128,404)	(42,310)	(12,001,627)
Хэвийн зээл рүү	4,752,744	(4,066,417)	(585,976)	(96,777)	(3,573)	0
Хугацаа хэтэрсэн зээл рүү	(7,881,373)	8,287,011	(390,410)	(15,228)		(0)
Хэвийн бус зээл рүү	(25,815)	(2,432,777)	2,577,601	(119,008)		(0)
Эргэлзээтэй зээл рүү	(115,772)		(831,392)	947,164		-
Муу зээл зээл рүү	(3,306)			(206,680)	209,985	-
Эцсийн үлдэгдэл	16,880,113	1,408,682	620,971	413,016	249,615	19,572,397

Тайлант онд 3,305.6 мянган төгрөгийн хэвийн зээл, 206,679.5 мянган төгрөгийн эргэлзээтэй зээлийг муу зээл рүү, 115,771.9 мянган төгрөгийн хэвийн, 831,391.9 мянган төгрөгийн хэвийн бус зээлүүдийг эргэлзээтэй зээл рүү, 25,815.1 мянган төгрөгийн хэвийн, 2,432,777.2 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, 119,008.5 мянган төгрөгийн эргэлзээтэй зээлүүдийг хэвийн бус зээл рүү, 7,881,372.7 мянган төгрөгийн хэвийн зээл, 390,410.0 мянган төгрөгийн хэвийн бус зээл, 15,228.3 мянган төгрөгийн эргэлзээтэй зээлүүдийг хугацаа хэтэрсэн зээл рүү, 4,066,417.3 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн, 585,976.1 мянган төгрөгийн хэвийн бус, 96,777.3 мянган төгрөгийн эргэлзээтэй, 3,573.5 мянган төгрөгийн муу зээлүүдийг хэвийн зээлийн ангилал руу тус тус шилжүүлж бүртгэсэн байна.

2023 оны 12 дугаар сарын 31-нээрх шүүх, заргатай холбоотой зээлийн мэдээлэл

Зээлийн дүн	Төлбөр	Одоо байгаа дүн
	нэхэмжлэх	
	118,510,832	92,122,832

Нийт зээлийн 0.47% буюу 92,122.8 мянган төгрөгийн шүүхийн шийдвэртэй холбоотой зээлийн үлдэгдэлтэй байна.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Зээлийн эрсдэлийн сан**

<i>Активын ангилал</i>	<i>Хувь хэмжээ</i>	<i>Зээлийн эрсдэлийн сан</i>
<i>Хугацаа хэтэрсэн зээл</i>	5%	70,434,096
<i>Хэвийн бус зээл</i>	25%	155,242,831
<i>Эргэлзээтэй зээл</i>	50%	206,507,807
<i>Муу</i>	100%	249,614,900
Нийт дүн		681,799,633

**Зээлийн эрсдэлийн санг 76 зээлдэгчийн 1,408,681.9 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, 32 зээлдэгчийн 620,971.3 мянган төгрөгийн хэвийн бус зээл, 21 зээлдэгчийн 413,015.6 мянган төгрөгийн эргэлзээтэй зээл, 13 зээлдэгчийн 249,614.9 мянган төгрөгийн муу зээлийн үлдэгдлээс Санхүүгийн зохицуулах хорооны “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах” журмын дагуу хувь хэмжээгээр байгуулж тогтоосон байна.

<i>Зээлийн эрсдэлийн санг хөдөлгөөнөөр харуулал:</i>	12/31/2023	12/31/2022
<i>Эхний үлдэгдэл</i>	139,608,458	287,988,867
Тайлант жилд нэмж байгуулсан	659,876,952	68,676,893
Сангаас буцаасан	(117,685,778)	(268,211,599)
<i>Эцсийн үлдэгдэл</i>	681,799,633	88,454,160

Тайланд онд 659,877.0 мянган төгрөгөөр зээлийн эрсдэлийн сан нэмж байгуулан, 117,685.8 мянган төгрөгийн эрсдэлийн санг буцааж бүртгэсэн.

8. БУСАДАВЛАГА

	12/31/2023	12/31/2022
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага	522,876,489	259,179,859
	522,876,489	259,179,859

Зээлийн гэрээний дагуу хүүгийн авлагыг хуримтлуулан бүртгэдэг.

9. БУСАД ХӨРӨНГӨ

	12/31/2023	12/31/2022
Урьдчилж төлсөн тооцоо	6,840,451	3,396,885
Урьдчилж төлсөн тооцоо цалин хөдөлмөрийн хөлс	14,000	2,845
	6,854,451	3,399,730

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Өртөг	Барилга байгууламж	Тавилга эд хогшил	Компьютер түүний дагалдах хэрэгсэл	Тээврийн хэрэгсэл	Нийт
1/1/2023	191,000,000	23,611,839	31,234,507	283,000,000	528,846,346
Худалдан авсан		634,900	3,714,850		4,349,750
12/31/2023	191,000,000	24,246,739	34,949,357	283,000,000	533,196,096
Хуримтлагдсан элэгдэл					
1/1/2023	3,033,333	3,219,757	19,630,614	16,508,333	42,392,037
Тайлант жилд байгуулсан	7,640,000	2,387,937	9,326,476	28,300,000	47,654,413
12/31/2023	10,673,333	5,607,694	28,957,089	44,808,333	90,046,450
Үлдэгдэл өртөг					
12/31/2023	180,326,667	18,639,045	5,992,268	238,191,667	443,149,646

11. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Өртөг	Программ хангамж*	Бүгд
1/1/2023	5,213,000	5,213,000
Худалдаж авсан	-	-
12/31/2023	5,213,000	5,213,000
Хуримтлагдсан хорогдол		
1/1/2023	3,282,479	3,282,479
Тайлант жилд байгуулсан	731,230	731,250
1/1/2023	4,013,729	4,013,729
Үлдэгдэл өртөг		
12/31/2023	1,199,271	1,199,271

*Интерактив Би Ай ХХК-ийн Спинел 6.0 санхүүгийн програмтай.

12. ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ

	12/31/2023	12/31/2022
Итгэлцлийн үйлчилгээний өглөг*	4,957,963,733	3,464,131,003
	4,957,963,733	3,464,131,003

*Тайлант онд 5 иргэн, 1 хуулийн этгээдүүдтэй итгэлцлийн гэрээ хийсэн. Итгэлцлийн үйлчилгээний өглөг нийт өр төлбөрийн 90%-ийг эзэлж байна. Дундаж өгөөжийн хувь 12-13% байна.

13. БУСАД ӨР ТӨЛБӨР

	12/31/2023	12/31/2022
Хуримтлуулж тооцсон бусад хүүгийн өглөг	242,423,544	111,520,839
Цалингийн өглөг	0	-
Орлогын албан татварын өглөг	191,651,895	177,832,180
ХХОАТ-н өглөг	5,687,054	3,756,069

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

13. БУСАД ӨР ТӨЛБӨР (ҮРГЭЛЖТЭЛ)

Суутган төлөгчийн хувь хүнд олгосон орлогод ногдуулан суутгасан албан татварын өглөг	73,508,681	8,337,912
Бусад өглөг	50,874	-
Бусад өглөг	19,612	-
	513,341,660	301,447,000

14. ХУВЬЦААТ КАПИТАЛ

	12/31/2023	12/31/2022
Хувьцаа*	3,468,668,428	3,468,668,428
Халаасны хувьцаа	(3,569,520)	(3,569,520)
	3,465,098,908	3,465,098,908

*Хувьцаа нь 2.3 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,508,116,708 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.
 ББСБ-ын олон нийтэд арилжаалсан хувьцаа нь хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгэлтэй байна.

15. НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ

	12/31/2023	12/31/2022
Нэмж төлөгдсөн капитал	8,779,112,743	8,779,112,743
	8,779,112,743	8,779,112,743

16. ХУРИМТЛАГДСАН АШИГ (АЛДАГДАЛ)

	12/31/2023	12/31/2022
Эхний үлдэгдэл	2,012,224,534	979,761,261
Тайлант хугацааны ашиг	3,303,434,505	1,993,615,954
Зарласан ногдол ашиг*	(1,990,336,642)	(961,188,101)
НББ-ийн залруулга	-	35,421
Эцсийн үлдэгдэл	3,325,322,398	2,012,224,534

*Тайлант онд 3,303,658.8 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, ТУЗ-ийн 2023 оны 4 дүгээр тогтоолын дагуу ББСБ-ын хувьцаа эзэмшигчдэд нэгж хувьцаанд 1 төгрөг 32 мөнгөн ногдол ашиг хуваарилсан.

17. ХҮҮГИЙН ОРЛОГО

	12/31/2023	12/31/2022
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого /Хувийн сектор/	253,944,799	254,045,601.39
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого /Иргэдийн/	5,176,154,194	2,797,643,562
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого /Хувийн сектор/	247,055	-
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого /Иргэдийн/	20,772,960	1,127,813
Банкин дахь харилцах дансны хүүгийн орлого	17,106	-
Хүүгийн орлогын буцаалт /сөрөг утгатай/	(36,122)	(888,056)
	5,451,099,992	3,051,928,920

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18 ХҮҮГИЙН БУС ОРЛОГО

	12/31/2023	12/31/2022
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	72,188,575	86,940,045
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	53,133	94,995,379
Гадаад валютын арилжааны орлого	40,502	-
	72,282,210	181,935,424

19 ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ

	12/31/2023	12/31/2022
Гадаад валютын арилжааны зардал	35,420.00	-
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	196,168	172,808,447
Үндсэн болон нэмэгдэл цалин	154,221,910	148,375,342
ТУЗ-ийн цалин	75,946,248	35,280,000
Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	28,575,681	22,857,262
Сургалтын зардал	3,038,040	2,066,000
Ажилтнуудад олгосон нөхөн олговор, хөнгөлөлт	575,440	1,264,079
Ажилтануудад олгосон тэтгэмж	210,242	485,927
Албан томилолт	43,272,820	26,724,720
Түрээс	16,980,850	17,395,000
Зээл болон түүнтэй холбоотой ашигын барагдуулахтай холбогдсон гарсан зардал	1,222,527	903,000
Элэгдэл, хорогдол	48,385,663	31,375,484
Үндсэн хөрөнгийн урсгал засвар борлуултын үйл ажиллагааны зардал	-	4,061,000
Харилцаа холбоо, интернет	6,555,241	4,686,765
Шатахуун болон тээврийн зардал	9,879,856	8,194,178
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ	408,000	-
Зохицуулалтын хураамжийн зардал	91,671,605	166,841,265
Харуул хамгаалалтын зардал	1,320,000	1,360,000
Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа	36,500,000	1,200,000
Бичиг хэргийн зардал	3,545,490	9,064,270
Ариун цэврийн зардал	716,796	489,044
Хангамжийн материалын зардал	1,163,416	1,463,013
Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан зардал	651,755,136	223,019,182
Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ	4,809,200	3,178,000
Даатгал	4,946,920	374,220
Хуулийн зөвлөгөө авах өмгөөллийн үйлчилгээний зардал	13,000,000	2,000,000
Үндсэн бус үйл ажиллагааны бусад зардал*	12,214,221	1,288,880
Бусад	39,286,015	5,613,398
Шимтгэлийн зардал	247,402	7,400,025
	1,250,680,306	899,768,500

*Нийт хуугийн бус зардлын 12%-ийг цалингийн зардал эзэлж байна.

ББСБ 2023 оны 12 дугаар сарын 31-нээр ТУЗ-ийн гишүүдийг оролцуулан 16 ажилчидтай байна.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

20. ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ

	12/31/2023	12/31/2022
Тайлант жилд нэмж байгуулсан	542,191,175	103,033,193
Сангаас буцаасан	-	(51,878,895)
	<u>542,191,175</u>	<u>51,154,298</u>

*ББСБ нь зээлийн эрсдэлийн зардлыг Санхүүгийн зохицуулах хорооны “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу хувь хэмжээгээр байгуулж, зээлийн эрсдэлийн санг тооцож, уг зөрүүгээр зээлийн эрсдэлийн зардлыг тооцож бүртгэдэг.

21. ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

	12/31/2023	12/31/2022
Бусад орлого*	550,000	267,300
	<u>550,000</u>	<u>267,300</u>

*ББСБ-ын нэр дээрх авто зогсоолоос орсон орлого.

22. ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	12/31/2023	12/31/2022
Зочин төлөөлөгчийн зардал	49,567,049	34,053,307
Баяр ёслолын зардал	4,774,832	14,982,945
Үндсэн бус үйл ажиллагааны бус бусад зардал	-	13,232,076
	<u>54,341,881</u>	<u>62,268,328</u>

23. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

	12/31/2023	12/31/2022
Орлогын албан татварын зардал	373,284,334	227,324,564
	<u>373,284,334</u>	<u>227,324,564</u>

*Орлогын албан татварын зардлыг ААНОАТ-ын тухай хуулийн дагуу тооцож, бүртгэсэн.

23. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	12/31/2023	12/31/2022
<i>Татварын өмнөх ашиг (алдагдал)</i>	3,676,718,840	2,220,940,518
Татварын өмнөх ашгаас тооцсон татварын зардал 10%	367,671,884	222,094,052
Нэмэгдүүлэх нөлөөлөл	5,612,450	5,230,512
Бууруулах нөлөөлөл	-	-
<i>Нийт орлогын татварын зардал</i>	<u>373,284,334</u>	<u>227,324,564</u>